



**УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ**

2019 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/144

Улаанбаатар хот


**Ажлын хэсэг байгуулах тухай**

Агаарын тухай хуулийн 8 дугаар 8.1.1, Монгол улсын Засгийн газрын 2018 оны “Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, “Түүхий нүүрсний хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаас өгсөн үүргийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Агаар, орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд, түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон бүсэд байрлах тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа 16кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зуухнуудын мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, төвлөрсөн дулаан, цахилгаан хангамжид холбох, сэргээгдэх эрчим хүчээр халаах техникийн шийдэл боловсруулах, 1110 ширхэг утаа шүүгч суурилуулах боломжийг судалж дүгнэлт гаргах, тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн нүүрс тээвэрлэлт, ашиглалтыг хэрхэн зохион байгуулах талаар санал боловсруулж танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Ажлын хэсгийн үр дүн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаархи саналыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерт 14 хоног тутамд танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг /Т.Хэрлэн/-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА *[Signature]* Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 05 сарын 20 өдрийн  
... тушаалын хавсралт



### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:	Т.Хэрлэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
Гишүүд:	Ч.Гантулга	Нийслэлийн иргэдийн Хурлын Төлөөлөгч, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны нарийн бичгийн дарга
	Э.Энхцэцэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
	Ц.Рэгзэдмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн дарга
	Б.Эрдэнэчимэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	И.Даваажамьян	Цагдаагийн ерөнхий газрын хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны хүрээлэн буй орчны хяналтын хэлтсийн дарга, Цагдаагийн Хурандаа
	Б.Цацрал	Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын дарга
	С.Санжмятав	Нийслэлийн Байгаль орчны газрын орлогч дарга
	Э.Батбилэг	Баянгол дүүргийн Засаг даргын орлогч

Т.Батцогт	Баянзүрх дүүргийн Засаг даргын орлогч
Ц.Шижир	Сүхбаатар дүүргийн Засаг даргын орлогч
О.Ганбаатар	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын орлогч
Г.Батсайхан	Хан-Уул дүүргийн Засаг даргын орлогч
Ж.Лхагвасүрэн	Чингэлтэй дүүргийн Засаг даргын орлогч
Н.Шинэ-Оргил	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Агаарын чанарын хэлтсийн дарга
Б.Оюунтуяа	Хот Байгуулалт, хөгжлийн газрын Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дарга
Ө.Чулуунцэцэг	Эрчим хүчний зохицуулах хорооны Хэрэглэгч орон нутгийн хэлтсийн мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
Э.Батмөнх	Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК-ний Үйлдвэрлэл, хөгжлийн хэлтсийн дарга
Б.Аззаяа	Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК Техникийн бодлогын хэлтсийн дарга
Г.Одончойжав	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар /ОНӨААТҮГ/-ын Ерөнхий инженер
Б.Бямбацогт	Монголын дулаан үйлдвэрлэл хангамжийн үндэсний холбоо НҮТББ /Зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга: Ц.Цолмон	Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар Бодлого зохицуулалтын хэлтсийн дарга
О.Батмөнх	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн